

ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн /гэмтлийн/ эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ /протез, ортопед/-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/507, А/112 дугаар тушаалаар жишиг үнийн жагсаалт шинэчлэн баталж, мөрдөж байна. Энэхүү тушаал нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5440 дугаарт бүртгэлтэй болно.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл боловсруулав.

Одоогийн мөрдөж байгаа тушаалаар 24 төрлийн протез, ортопедийн 121 00-11 000 000 төгрөгийн зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлж байна.

Харин шинээр батлах жагсаалтад иргэдээс ирсэн саналын дагуу бионик хиймэл эрхтэн (15 000 000 төгрөг) гэсэн төрөл нэмсэн. Бионик хиймэл гарын өөрийн өртөг олон улсын түвшинд 10.0-100.0 мянган ам.долларын өртөгтэй боловч манай улсад 5.0 мянган ам.доллараар хийж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын саналын дагуу гавлын ясны цоорхойг титан тороор нөхөх (1 200 000), шилэн нүд (85 000 төгрөг), дунд чихний титан протез (350 000 төгрөг), хүзүү, нурууны ясны титан бэхэлгээ /1 үе/ (8 500 000 төгрөг) гэсэн 4 төрлийг шинээр нэмсэн.

Мөн хиймэл болор (460 000 төгрөг), нэг гарын протез (3 000 000 төгрөг), сонсголын дижитал аппарат /1 чих/ (2 000 000 төгрөг) гэсэн 3 төрөлд тус бүр үнийг нэмэгдүүлсэн. Бусад төрөлд одоогийн жишиг үнийг 10 хувиар нэмэгдүүлсэн болно. Шинэ батлах жагсаалтын дагуу 29 төрлийн протез, ортопедийн 85 000-15 000 000 төгрөгийн зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх болно.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 6219 иргэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байгаа бөгөөд үүнээс протез, ортопед хийлгэсэн 4 хүн, түүний зардал 5.1 сая төгрөг (2022 онд протез ортопед хийлгэсэн 9 хүн, түүний зардал 7.6 сая төгрөг) байна. 2023 онд хиймэл эрхтэн, засал эмчилгээний зардалд 120.5 сая төгрөг төсөвлөсөн, 2024 онд 241.1 сая төгрөг төсөвлөсөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлагдсанаар Нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт зардал гарахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлах хууль эрх зүйн үндэслэл

Одоогийн мөрдөж буй хууль:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дах хэсэгт:

“Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн /гэмтлийн/ эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ /протез, ортопед/-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж,

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх шинэ хууль:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дах хэсэгт:

“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж тус тус заасан.